

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН
БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАНГАХ ХҮСНЭГТ**

(2025 он)

Хүснэгт 3.6

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	19	19	Тайлант хугацаанд байгууллагаас албан хаагчдын мэдлэг, ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор дотоод болон гадаад эх үүсвэрээр сургалт семинар, зөвлөгөөнд хамруулан ажиллалаа. Үүнд: ➤ Дотоод сургалт-12 ➤ Туршлага солилцож хамтран зохион байгуулсан сургалт, семинар-19 ➤ Мэргэжлийн дагуу зөвлөгөө, уулзалт, хэлэлцүүлэг-12 Эдгээр арга хэмжээ нь эмч мэргэжилтнүүд болон ажиллагсадын мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэл, шинэ санаа санаачлах, үйлчилгээний чанарыг сайжруулахад бодит үр нөлөө үзүүлсэн.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	15	15	Дотооддоо 15 сургалт зохион байгуулсанаас давхардсан тоогоор 603 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. Үүнд: ➤ Амилуулах суурь тусламжийн сургалтыг ЭЭЯТ ийн тасгийн их эмч М.Сарантуяа, ЭЭЯТ-ийн тасгийн ахлах сувилагч Ч.Дэжидмаа нар удирдан явуулсан. Сургалтанд оролцогчдын тоо-21 ➤ “Лайеллын хам шинж болон анафилакси шокийн үеийн яаралтай тусламж оношилгоо авах арга хэмжээ” сэдэвт 1 багц цагийн төлбөртэй сургалт АӨСҮТ -ийн хурлын зааланд зохион байгуулагдсан. Сургалтанд 49 эмч хамрагдсан. ➤ Шинээр элсэн суралцаж буй АӨСҮТ, АШУҮИС-ийн 26

						резидент эмч нарт Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сэдэвт сургалтын хүрээнд Өвчний түүх бичилт, E-health программд ажиллах, үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээ мөрдөж ажиллах хөтөлбөрийн агуулгаар ЭМТҮЧАБА-ны дарга Ж.Булган удирдан явуулсан. ➤ Шинээр элсэн суралцаж буй АӨСҮТ, АШУҮИС-ийн 27 резидент эмч нарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал” -ын талаарх сургалтыг ХАБ-ын мэргэжилтэн Б.Сүхболд удирдан явуулсан. ➤ Шинээр ажилд орж байгаа эрүүл мэндийн ажилчид, резидент эмч нарт “Халдварын сэргийлэл хяналтын стандарт” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтанд 38 ажилчид хамрагдсан. ➤ “Гарын эрүүл ахуй” сэдвээр Тархвар судлаач Э.Нарантуяа эмч, ажилчдад сургалт хийсэн. Сургалтанд нийт 52 ажилчид хамрагдсан. ➤ Шинээр ажилд орсон, шинээр элсэн суралцаж буй АӨСҮТ, АШУҮИС-ийн 26 резидент эмч нарт “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт сургалтыг ХСХА-ны халдвар судлаач Нарантуяа холбогдох бодлогын баримт бичгийн хүрээнд сургалт удирдан явуулав. ➤ АӨСҮТ-ийн эмч нарт “Арьсны мөөгөнцөрт өвчний, оношилгоо, эмчилгээ” сэдэвт сургалтыг МУ-ын хүний гавьяат эмч, АУ-ны доктор, профессор, зөвлөх эмч Б.Хандсүрэн удирдан явуулсан сургалтанд оролцогч-28 ➤ “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” сэдэвт аяны хүрээнд тасаг, нэгж тус бүр 2 удаагийн зөвлөн чиглүүлэх, туслан дэмжих зорилготой хууль эрх зүй, хүний эрх, ёс зүйн холбогдолтой зохион байгуулсан сургалтад 54 эмч мэргэжилтэн ➤ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, түүний ач холбогдол” сэдэвт 2 удаагийн сургалтад АӨСҮТ-ийн резидент 9 эмч, эмч эмнэлгийн мэргэжилтэн 25
--	--	--	--	--	--	---

					➤ “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр зохион байгуулсан сургалтад 34 эмч мэргэжилтэн хамрагдсан. ➤ “Мэргэжилтэний ёс зүй” сэдвээр 1 кр цагийн онлайн сургалт зохион байгуулж нийт 19 эмч мэргэжилтэй оролцсон ➤ "Сувилахуйн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ" сэдэвт сургалтыг Хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х.Эрдэнэтуяа удирдаж ЭМС-ын А/319 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт шинэчлэгдсэн заалтуудыг таниулан чиглүүлэх сургалтад Сувилагч-15, Туслах сувилагч-3, Тусгай дунд мэргэжилтэн-8 нийт 25 сувилагч мэргэжилтэн хамрагдлаа. ➤ Хэвтэн эмчлүүлэгч нарт үйлчлүүлэгчдийн эрх, үүргийг танилцуулах сургалтыг Ёс зүйн хорооны гишүүн Х.Эрдэнэтуяа танилцуулж хэрэгжүүлсэн бөгөөд 1, 2-р тасгийн эмчлүүлэгч-15 иргэн, Хүүхдийн тасгийн сахиур болон эмчлүүлэгч 18 нийт 33 иргэн хамрагдсан. ➤ Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд мөрдөх нийтлэг журам” сэдвээр эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага BNS 7014:2023 сэдвээр хийсэн сургалтад 15 эмч мэргэжилтэнг хамруулсан.
		Мэргэшүүлэх сургалт	4	4	Эрүүл мэндийн ажилтны хөгжлийг дэмжиж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгын хүрээнд: Нийт 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 5 эмч, 2 сувилагч төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамруулсан. Үүнд: ➤ АШУҮИС-ийн арьсны мэс засал судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтанд поликлиникийн тасгийн их эмч Ч.Эрдэнэчимэг, ЭГЗНСТ-ын эмч М.Жамбалсүрэн нар 2025 оны 10 сараас 1 жилийн хугацаанд суралцаж байна. ➤ Поликлиникийн эрхлэгч Г.Цогзол ЭМХТ-ийн ЭМТҮЧАБА-ны менежер төрөлжсөн мэргэшлийн сургалтанд УХТЭ-т суралцаж байна. ➤ Арьсны сувилахуйн сургалтанд төвөөс 2 сувилагч суралцуулсан О.Даваасүрэн, О.Шоовдор нар Клиникийн 2

						дугаар тасаг, хүүхдийн тасагт ажиллаж байна. ➤ АШУҮИС-ийн МДИ нь арьсны эд судлалын төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр 2024-2025 оны хичээлийн жилд 2 эмч суралцаж төгссөн.
			Туршлага солилцох арга хэмжээ	13	13	Бусад байгууллага, сургагч багштай хамтарсан 13 чиглэлийн сургалт зохион байгуулж туршлага, мэдээлэл солилцсон давхардсан тоогоор АӨСҮТ-ийн эмч мэргэжилтэнгүүд болон бусад байгууллагын 749 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Үүнд: ➤ Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, Зөвлөх эмч Б.Хандсүрэн, Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг, Зөвлөх эмч Г.Цогзол нараар удирдуулсан “Арьсны өвчний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг орон нутагт сайжруулахад хувь нэмэр оруулах нь” сэдэвт сургалт уулзалтыг орон нутаг, дүүргийн арьсны эмч нартай хамтран төвийн байранд зохион байгуулсан бөгөөд сургалтын явцад нээлттэй хэлэлцүүлэх арга хэмжээ мөн АӨСҮТ-ийн тасаг нэгжүүдийн зохион байгуулалт, шинээр нэвтрүүлсэн технологи, оношилгоотой танилцаж туршлага судалж 60 эмч мэргэжилтэн оролцсон үр дүнтэй арга хэмжээ болсон. ➤ Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага” үндэсний хэлэлцүүлэгт ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга оролцсон. ➤ Зөвлөх эмч Б.Хандсүрэн, төвийн Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг нар Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжил арга зүйгээр хангаж 1 багц цагийн төлбөртэй сургалт зохион байгуулж сургалт арга зүйн чиглэлээр санал солилцсон бөгөөд нийт 56 эмч мэргэжилтнийг хамруулсан. ➤ “Ургамлын тоосны харшил өвчний шалтгаан, өвөрмөц

						аллерген дархлаажуулах эмчилгээний орчин үеийн чиг хандлага” сэдэвт 1 багц цагийн төлбөртэй сургалт зохион байгуулсан. Сургалтыг танхим болон цахим хэлбэрээрэмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан ба уг сургалтыг АӨСҮТ-ийн дотор харшил судлалын эмч АУ-ны доктор С.Байгалмаа удирдан явуулсан. Урилгаар “Анагаахын шинжлэх ухааны доктор Г.Н.Габричевскийн нэрэмжит Эпидцимиологи, микробиологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Мачарадзе Дали Шотаевна хүрэлцэн ирж Гипер IGE синдром сэдвээр сургалт мэдээлэл өгсөн ба сургалтад 160 эмч мэргэжилтэн оролцсон. ➤ “Арьсны зонхилон тохиолдох эмгэгүүдийн оношилгоо, авах арга хэмжээ” сэдэвт сургалт зохион байгуулж сургалтад орон нутгийн төр, хувийн хэвшил, дүүргийн арьсны эмч нар болон төвийн эмч нар, нийт 60 мэргэжилтэн хамрагдсан. ➤ АӨСҮТ-ийн Харшил судлалын лабораторийн 20 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан “Ургамлын тоосны харшил өвчний шалтгаан, өвөрмөц аллерген дархлаажуулах эмчилгээний орчин үеийн хандлага” сэдэвт 1 кр багц цагийн сургалт амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтад 110 мэргэжилтэн хамрагдсан. ➤ Их эмч Ж.Аззаяа, Б.Дашдулам нар Их эмч Ж.Аззаяа, Б.Дашдулам нар “Lupus erythematosus” сэдвээр эмч нарт эмнэл зүйн ховор тохиолдолт өвчний талаар мэдээл өгч туршлага солилцож хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэг сургалтад нийт 28 эмч мэргэжилтэн хамрагдсан. ➤ Баянхонгор аймгийн “Шаргалжуут” рашаан сувилалд АШУҮИС-йн арьс судлалын тэнхим, АСМН-тэй хамтран зохион байгуулсан “Эозинофилийн болон Нейтрофилийн дерматоз” өвчний оношилгоо эмчилгээ сэдэвт сургалт,
--	--	--	--	--	--	--

						хэлэлцүүлэгт АӨСҮТ-өөс 2 эмч мэргэжилтэн хамрагдсан. ➤ “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чиг хандлага” сэдэвт ОУ-ын бага хуралд удирдах 2 ажилтан оролцож туршлага мэдээлэл солилцсон. ➤ ЭМЯ, Арьс судлалын салбар зөвлөл, АӨСҮТ, АШУҮИС, АСМН-ээс хамтран зохион байгуулсан “Арьс судлалын салбар 2030” нээлттэй хэлэлцүүлэгт төвийн захирал Ц.Уранчимэгээр ахлуулсан нийт 6 эмч мэргэжилтэн оролцсон. ➤ АШУҮИС-аас 4 дэх удаагаа зохион байгуулж буй “Эмнэлгийн менежмент” олон улсын хурал, хэлэлцүүлэгт цахимаар 27 эмч мэргэжилтэн оролцож санал солилцож туршлага судалсан. ➤ 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр орон нутаг, дүүргийн арьсны эмч нарын сургалт, уулзалтыг АӨСҮТ-ээс зохион байгуулсан. Арьсны өвчний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг орон нутагт сайжруулахад хувь нэмэр оруулах, орон нутаг, дүүргийн арьсны эмч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах мэргэжил арга зүйгээр хангах зорилгоор төвийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, СЭША хамтран зохион байгуулагдсан. Сургалтанд оролцогчидод үнэ төлбөргүй, 1 багц цаг олгов. Сургалтанд оролцогчдын тоо-60 ➤ “Эрүүл мэндийн ажилтан ёс зүй, үнэ цэнэ” сэдэвт сургалт хэлэлцүүлэг төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт зохион байгуулагдахад ёс зүйн дэд хорооны гишүүн Х.Эрдэнэтуяа оролцсон.
			Бусад	15	18	Арьс судлал үндсэн мэргэшлийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу танхимын, ажлын байран дахь сургалтын төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг хичээлийн жилээр батлуулан хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна. Хичээлийн жилийн тойролт удирдах болон онолын

					хичээл удирдах багш томилох тухай төвийн захирлын 2025 оны А/30 тоот тушаалаар томилон багш нартай гэрээ хийж ажиллаж байна. Үүнд: 1. Эрдэм шинжилгээний хурал-2 2. Хурал-2 3. Өдөрлөг-1 4. Аян-3 5. Илтгэл-2 6. Эссэ бичлэгийн уралдаан-1 7. Зөвлөгөө, зөвлөмж-25185 8. Мэдээ мэдээлэл-600 9. Гарын авлага-12 төрөл ➤ 2023 -2025 оны үндсэн мэргэшлийн сургалтын төсгөлтийн шалгалт амжилттай зохион байгуулагдаж нийт 13 суралцагч гардан дадлага шалгалтдаа тэнцэж 100 хувийн үзүүлэлттэйгээр амжилттай төгссөн. ➤ 2025-2026 оны хичээлийн жилд “арьс судлал” үндсэн мэргэшлийн сургалтад 1 болон 2-р дамжаанд нийт 25 резидент эмч суралцаж байна. Үүнээс: 1-р дамжаанд 10 резидент, 2-р дамжаанд 15 суралцагч суралцаж байна. ➤ “Эрдмийн чуулган IX” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж нийт 11 илтгэл, 2 эмнэл зүйн тохиолдол хэлэлцүүлэгдсэн. Дараах хурлын илтгэлийн 54 нүүр эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг сургалтын албанас хянаж, хэвлэсэн. ➤ Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан “Арьсны эмгэг эд эсийн шинжилгээний онцлог” сэдэвт 1кр багц цагийн чадвахжуулах сургалтад 6 эмч оролцсон. ➤ Төрийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд НДЕГ-аас “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл” сэдэвт сургалтыг зохион байгуулж 71
--	--	--	--	--	---

						ажилтан албан хаагч оролцлоо. ➤ Амьдрах урлаг бясалгалын төвийн багш П.Баясгаланбаатар “Стресс, бухимдлаас ангижрах арга, бясалгалын ач тус” сэдэвт сургалтыг удирдан явуулсан ба 18 ажилтан хамрагдсан. ➤ “Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийн халдварт өртөх эрсдлийг бууруулах нь” сэдэвт онлайн сургалтыг АӨСҮТ-ийн цахим групп дээр нээлттэй байршуулж 112 хүнд хүргэсэн. ➤ Хүн амын дун эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй шинэлэг арга хэлбэрээр хүргэх зорилгоор “Хөлдөөх эмчилгээ”, “Батга”, “Хүнсний харшлаас сэргийлэх нь”, “Ягаан үлд”, Ургамлын тоосны харшил”, “Үс уналт”, “Тав дахь өвчин”, “Шинжилгээ өгөхөд анхаарах зүйлс”, “Улиасны унгирал”, “Хүнсний харшил” гэх төрлүүдээр телевиз, болон олон нийтийн мэдээ мэдээллийн сувгуудаар 10 удаагийн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан. ➤ Харшлын сорил тавих талаар поликлиникийн ахлах сувилагч зөвлөгөө зөвлөмж бэлтгэн байгууллагын пэйж, вэб хуудсаар дамжуулан мэдээлэл түгээж ажилласан. ➤ Төвийн хэмжээнд нийт 3 үндэсний хөтөлбөрийн хэмжээнд 11 арга хэмжээ хэрэгжүүлж, 14 төрлийн 5126 ширхэг гарын авлага тарааж ажилласан. ➤ Томуу томуу төст өвчлөл, арьс харшлын өвчлөл, халдварт өвчлөл зэрэг нийт 4 сэдвийн хүрээнд 210 /давхардсан тоо/ оруулж ажилласан. ➤ Байгууллагын фэйсбүүк болон пэйж хуудсанд 600 /давхардсан тоо/ мэдээ мэдээллийг бэлтгэн нийтэлж олон нийтэд хүргэсэн. ➤ Нийт үйлчлүүлэгч нарт зориулан цахим бүртгэлийн
--	--	--	--	--	--	---

					хэсэгт лед дэлгэц суурилуулж эрүүл мэндийн анхан шатны боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг байгууллагын вэб, фэйсбүүк хуудас, телевиз, дотоод сүлжээг ашиглан цахим болон хэвлэмэл байдлаар гаргаж нийт 25185 иргэнд хүргэж ажилласан. Иргэд үйлчлүүлэгчид арьсны зонхилон тохиолдох эмгэгүүдийн эмчилгээ, урьдлан сэргийлэх талаар анхан шатны мэдлэгтэй болж байна. ➤ Амбулатори болон тасгаар үйлчүүлэгч иргэд эмч ажилчдад зориулан “Харшлын сорил тавиулхад анхаарах зүйлс”-ийн талаар 34, “Батга өвчин”- 45, “Улаан бурхан өвчний халдвараас урьдчилан сэргийлэх”-35, “чийгшүүлэх тос”-32, “Гараа хэрхэн зөв угаах вэ”-56, “Дааврын тосон түрхлэг”-34, “Цусны даралт-47, “Шинжилгээ өгхөд анхаарах зүйс”-37, “Эмийн зохистой хэрэглээ”-32, “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлье”-42, “Биеийн жингийн индекс”-46, “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх”- 2 төрлийн 67, “Хүнсний харшил”-47, “Усан эмчилгээ”-30 ширхэг гарын авлагуудыг тус тус хэвлэн бэлтгэж тараан сурталчлан таниулж ажилласан. ➤ “Хүнсний харшлын талаар мэдлэг олгох” өдөрлөг зохион байгуулж ажилчдын хүүхэд болон “Хүүхэд залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор”-ийн 40 хүүхэд залуучуудад батгатай арьс арчилгааны талаар зөвлөгөө өгч үзлэг хийсэн. Өдөрлөгийн үеэр хүүхэд залуусын дунд АХА тэмцээн зохион байгуулж 1,2,3-р байр шалгаруулж ахлах сувилагч Ч.Дэжидмаа хувийн зүгээс урамшуулал болгож цүнх бэлэглэсэн. Мөн Isispharma-тай хамтран тус төвийн хүүхдүүдэд арьс арчилгааны бүтээгдэхүүн болон гарын бэлэг тараасан. ➤ Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний
--	--	--	--	--	--

					хорооноос” Хайраа хайрлая, Хандлагаа өөрчилъе, хамтдаа үлгэрлъе” уриатай аян эхлүүлсэн ба тус аянд АӨСҮТ-ийн нийт ажилтан, хамт олон нэгдэн ажиллаж байна. ➤ Байгууллагын ёс зүйн дэд хороотой хамтран “Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол” сэдвээр эссэ бичлэгийн уралдааныг 14 хоногийн хугацаатай зарлаж 9 эссэ бичлэг ирснээс 1, 2, 3-р байр эзлүүлж гарын бэлэг батламж олгосон. ➤ Ажилтнуудын хууль эрх зүй, ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын дотоод журмын мөрдлөг, сахилга хариуцлагыг сайжруулах цаашид хөдөлмөр эрхлэлтэд гарч болох эрсдлээс сэргийлэх зорилгоор ажилд шинээ томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн, өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 32 эмч мэргэжилтэнд зөвлөгөө чиглүүлэг өгч ажилласан. Олон улсын хурал семинарт 3 илтгэл хэвлэн нийтлүүлэхээр илгээсэн. Үүнд: ➤ Амбулаторийн тасгийн эрхлэгч Г.Цогзол, их эмч М.Отгонбаяр, Д.Лхагвасүрэн нарын " Tuberculosis sclerosis сэдэв"- т эмнэлзүйн тохиолдол American Academy of Dermato-Pathology -ийн ОУ-ын хурлын хураангуй номд хэвлүүлэхээр илгээсэн. ➤ Их эмч Г. Цогзол, М.Отгонбаяр, Б.Номин, М.Жамбалсүрэн нарын бэлтгэсэн “Senear-Usher Syndrome” эмнэлзүйн тохиолдол "Ховор тохиолдох өвчин"-талаар 2026 оны 7-р сард Франц улсад болох Дэлхийн конгресст илгээсэн. ➤ Их эмч М.Отгонбаяр, Б.Номин, М.Жамбалсүрэн нар 12th ASMPD – Asian Society for Pediatric Dermatology Congress, Manila 2025 хуралд “Epidermal naevus syndrome” сэдэвт эмнэлзүйн тохиолдлоо өгч хэвлэхээр илгээсэн.
	1.2	Хамрагдсан	139	139	2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 139 үндсэн

			нийт албан хаагчдын тоо			ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа ба 100%-ийн оролцоотойгоор сургалт, илтгэл, хэлэлцүүлэгт оролцсон.
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	126	126	9 тасаг, 2 нэгжийн 139 ажилтан төвөөс болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, мэдээлэл, илтгэл, танилцуулга хэлэлцүүлэгт тойрох журмаар 100%-ийн оролцоотой оролцсон.
			Эрэгтэй албан хаагч	13	13	Аж ахуйн алба 9, их эмч 3 эрэгтэй албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
			Удирдах албан тушаалтан	18	18	АӨСҮТ-ийн захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал болон бусад алба тасгийн дарга эрхлэгч нар нийт 18 удирдах ажилтан зохион байгуулагдсан бүхий л сургалтуудад бүрэн хамрагдсан.
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	121	121	Гүйцэтгэх болон туслан гүйцэтгэх зорилготой 121 ажилтан тусгайлан буюу зорилтот сургалт, хэлэлцүүлэг, хуралд оролцсон.
		1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	100%	100%	
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	3	3	Олон улсын хурал семинарт 2 эмч, сургалтанд 1 эмч хамрагдсан. Үүнд: Туркийн Анталя хотод зохион байгуулагдсан “19th International Congress on Quality in Healthcare, Accreditation and Patient Safety” олон улсын конгресст Сургалт, Эрдэм шинжилгээний албаны дарга Б.Лхагвасүрэн “Detecting Adverse Events with the Global Trigger Tool: In case specialized hospital of Mongolia” сэдэвт аман илтгэлээр оролцсон. Амбулаторийн тасгийн эрхлэгч Г.Цогзол, их эмч А.Хулан нарын

	зардлаар хамруулсан гадаад сургалт					эмнэлзүйн тохиолдол АНУ-ын Калифорни мужийн Сан Дэйго хотод зохион байгуулагдсан Америкийн Арьс судлаачдын нийгэмлэгийн ээлжит хуралд “A rare case report of a teenage girl with pemphigus vegetans in Mongolia” эмнэлзүйн тохиолдол хэлэлцүүлсэн ба 2025 SID annual meeting Abstract Book номонд нийтлэгдсэн. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг Харвардын анагаах ухааны их сургуулийн “Leadership in medicine: Southeast Asia 2024-2025” хөтөлбөрийг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг амжилттай дүүргэсэн.
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	3	3	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	3	3	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	3	3	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
		2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	4%	4%	АӨСҮТ-нь 12 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 139 эмч мэргэжилтэн ажиллаж байгаа ба гадаад сургалтад хамрагдсан эмч мэргэжилтэн нийт ажиллагсадын 4%-ийг эзлэж байна.
3.	Албан	3.1	Албан	9	9	

	хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан шилжилт хөдөлгөөн		хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая төг)			Жил бүрийн суралцагчийн тоо нэмэгдэх, шилжилт, хүний нөөцийн хөдөлгөөнтэй уялдуулан, сургалтын багтаамжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөний дагуу 2 эмч сургагч багшийн сургалтад хамрагдсан. Арьсны сувилахуйн сургалтад 2 сувилагч суралцан төгсөж тасагт хувиарлагдан ажил үүргээ гүйцэтгэж байна. Төсгөлтийн дараах сургалтад 3 эмч, 2 сувилагч хамруулсан. Дотоод томилолт /орон нутгийн ижил төст байгууллагад сургалт зохион байгуулсан/ нийт 1,700,000 /нэг сая долоон зуун мянга/ төгрөг зарцуулсан
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	6	6	Тайлант хугацаанд байгууллагын албан хаагчдын шилжилт хөдөлөөгнийг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, хүний нөөцийн тогтвортой байлыг ханган ажиллалаа. Уг хугаанд албан хаагчдын ажлаас чөлөөлөгдөх, тэтгэвэрт гарах, шинээр томилогдох зэрэг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлээгүй болно.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшуулал тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь			Албан хаагчдын цалин хөлсийг албан тушаал, зэрэг дэв, ажлын ачаалал, хариуцлагатай уялдуулан тогтоосон бөгөөд цалин, урамшууллыг хууль тогтоомж болон дотоод журамд заасан хугацаанд бүрэн олгож нийгмийн даатгал, татаварыг хуульд заасны дагуу суутган шилжүүлсэн. Урамшууллыг ил тод, шударга, тэгш хүртээмжтэй олгож, дотоод хяналтыг ажиллуулсан.
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол унааны нэмэгдэл (мян.төг)	Унааны нэмэгдэл өдрийн 2500 төгрөг Хоолнын	5000	Унаа хоолны нэмэгдлийн хэмжээг эдийн засгийн нөхцөл, инфляцтай уялдуулан үе шаттайгаар шинэчлэх, хэрэгжилтийг хангах судалгааны ажил хийгдэж байна.

				эмэгдэл өдрийн 2500төгр өг		
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	11	100%	Төв нь ажилчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль журам, стандартын хүрээнд ажлын байрны хэвийн нөхцөлийг ханган ажиллахад зориулан доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Ажлын байрны гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан, чийгшлийг стандартын түвшинд байлгасан. ➤ Ажлын байрны цэвэрлэгээ ариутгалыг стандартын дагуу тогтмол хийж эрүүл ахуйн шаардлагыг хангуулсан. ➤ Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлийг тогтмол ариутгаж, амны хаалт, хамгаалах хэрэгслийг норм нормативийн дагуу олгон ажилласан. ➤ Ажлын байран дээр амны хаалт зүүх, гарын эрүүл ахуйг баримтлан ажиллах талаар "Маскаа зүүе" чөлөнж нөлөөллийн ажил зохион байгуулж төвийн эмч ажилчид богино хэмжээний рийл бичлэг хийж идэвхижүүлэв. ➤ Суралцагч резидент эмч өрөөнд суурин компьютер 1 ширхэгийг нэмж нийт 3 суурин компьютертэй болж сургалтын танхимын орчин нөхцөлийг сайжруулсан. ➤ Төвийн байгууламжид байрласан галын хор тус бүрийг сар тутамд шалгаж, ажиллагааг хянаж бүртгэл үүсгэн гарч болзошгүй гамшиг болон зайлшгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. ➤ Эмч ажилтан, үйлчлүүлэгчдийн анхаарал татахуйц гарах орох урсгалын чиглэлийг тусгасан тэмдэг тэмдэглэгээ 18 ширхэгийг тасаг бүрт байршуулсан. ➤ Ажилтан албан хаагчид болон үйлчлүүлэгчдийг арьс харшлын өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

						үзэлээр дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор нийт 11 ярилцлагыг хүргэж ажилласан. ➤ Цэвэрлэгээ ариутгалын ажлыг тогтмол зохион байгуулж, ариун цэврийн өрөөний хэрэглээ, хангамжийг сайжруулсан. ➤ Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж, илэрсэн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. ➤ Албан хаагчдын санал хүсэлтийг авч, орчныг сайжруулах, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхааран үе шаттайгаар арга хэмжээ авч ажиллаж байна. Албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах нөхцөл бүрдсэн бөгөөд ажлын бүтээмж, сэтгэл ханамж сайжирсан ба ажилтай холбоотой эрсдэл гомдол гараагүй.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийн хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд)	1-ээс дээш	6 100%	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадварыг нэмэгдүүлэх, аюулгүй, эрүүл ажлын орчныг бүрдүүлэхэд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: ➤ Цусанд Хеликобактери илрүүлэх шинжилгээнд 80 ажилтан хамруулсан ба үүнээс 18 хүн сөрөг, 62 хүн эерэг үзүүлэлттэй гарсан. Хеликобактери эерэг гарсан 62 хүнд зөвлөн чиглүүлэх үүднээс ходоодны дуран хийлгэх, стандарт эмчилгээг санал болгосон. ➤ Гепатит В, С вирусын халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд 125 эмч, ажилтанг хамруулсан. Шинжилгээний үр дүнд С-вирустэй 11 ажилтан, В-вирустэй 2 ажилтан илэрсэн. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. ➤ Төвийн эмч ажилчид болон резидент эмч нарыг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсанаас халдварын эерэг үзүүлэлт илрээгүй болно. ➤ Метициллинд тэсвэртэй стафилококк ауриус /MRSA/

						илрүүлэх шинжилгээнд 130 эмч ажилтан хамрагдсанаас нийт 32 хүн халдвартай гарсан. Халдвар илэрсэн ажилчдад “Balaban 2% Ointment” тосыг өглөө оройд 14 хоног хамрын хөндийд түрхэх, халдвар хамгааллын дэглэм сайтар баримтлах талаар дахин зөвлөмж өгч гарын авлагаар хангасан. ➤ Төвийн ажилчдаас хэвлийн эход харуулах хүсэлт гаргасан 27 ажилтанд үзлэг хийснээс цөсний ургацаг, цөсний чулуу, элэгний өөхжилт, бөөрний ангиомиолипома, бөөрний үрэвсэл, бөөрний чулуу, бөөрний уйланхай зэрэг өөрчлөлтүүд илэрсэн бөгөөд дараагийн шатны эмнэлэгт үйлчлүүлэх зөвлөгөө чиглэл өгсөн. ➤ Ажлын байранд амны хаалт зүүх, гарын эрүүл ахуйг баримтлан ажиллах талаар нөлөөллийн ажил зохион байгуулж ухуулга сурталчилгааны ажлыг өдөр тутамын мөрдлөг болгон ажилласан.
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100%	Эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь албан хаагчдын тогтвортой ажиллах нөхцөлийг хангахад чухал ач холбогдол өгсөн ба эрүүл амьдралын хандлага дээшилсэн, ажлын бүтээмж, сэтгэл ханамж нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ	(долоон сая зургаан зуун арван есөн мянга найман зуун арван зургаан	(долоон сая зургаан зуун арван есөн мянга найман зуун арван зургаан	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах дэмжлэгт орчныг сайжруулж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 10 ажилтанд 5,726,416 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон. ➤ Шинэ санааны өдөрлөгийг тасаг, эмч, ажилчдын дунд амжилттай зохион байгуулж 1-р байр 40 хувиар, 2-р байр 30 хувиар, 3-р байр 20 хувиар тус тус шагнагдсан. ➤ MNS ISO15189:2024, ISO9001:2015, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ, процесс сайжруулалт,

				төгрөг) /7.619.816 / төгрөг	төгрөг) /7.619.81 6/ төгрөг	зураглалаас шинжилгээ хүртэл- зэрэг сургалтуудад нийт 1,533,400 төгрөгөөр 6 ажилтан суралцсан. ➤ Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгө худалдан авах ажиллагааны АЗ-ын сургалтанд нийт 4 ажилтан хамрагдсан 360,000 төгрөг зарцуулсан.
--	--	--	--	-----------------------------------	-----------------------------------	--